



БӨӨНИЙ ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 4сарын 5 өдөр

Дугаар №ХЭ2014004

Улаанбаатар хот

БИГ МАЙНД ХХК-тай хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын  
чиглэлээр хамран ажиллах тухай

Бөөний худалдаа ХК-ийн 2014 оны 4 сарын 5-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62.2 дахь заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

НЭГ. Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж буй ШИНЭ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ хөтөлбөрийн хүрээнд, тус хөтөлбөрт албан ёсоор хамрагдаж байгаа СОЛОНГО хороолол орон сууцны төслийн үйл ажиллагааг эхлүүлсүгэй.

ХОЁР. Бүтээн байгуулалтын үйл ажиллагаа эхлүүлэхтэй хобогдон ТУЗ-ийн санал болгосон БИГМАЙНД ХХК-тай хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтран ажиллахыг зөвшөөрсүгэй.

ГУРАВ. Бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Компанийн эзэмшлийн Баянгол дүүргийн 20-р хороонд орших газраас хамтын гэрээ хэлцэл зөвшилцлийн санамж бчигт тусгасан хэмжээгээр тухайн газарт орших, барилгуудын (удахгүй актлагдах) хамт БИГМАЙНД ХХК-ийн эзэмшилд, хамтын ажиллагааны итгэл, баталгаа болгон шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

ДӨРӨВ. Хөрөнгө оруулалтын баталгаа гаргах ажлын хүрээнд Компанийн нэрийн өмнөөс гэрээ, хэлцэл хийх, эрх бүхий байгууллагад төлөөлөх эрхийг ТУЗ-ийн гишүүн Б.Очбадрахад итгэмжилсүгэй.

ТАВ. Бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийг цаг үеийн мэдээ, мэдээлээр ханган ажиллахыг ТУЗ-ийн нийт гишүүдэд даалгасугай.

ЗУРГАА. Үйл ажиллагаанд хяналт тавин, хариуцлага тооцон ажиллахыг Аудитын хороонд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ДӨЛБАДРАХ



БӨӨНИЙ ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 4сарын 5 өдөр

Дугаар №ХЭ2014003

Улаанбаатар хот

2014 оны бүтээн байгуулалтын төлөвлөгөөг батлах тухай

Бөөний худалдаа ХК-ийн 2014 оны 4 сарын 5-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

НЭГ. Компанийн 2014 оны бүтээн байгуулалтын төлөвлөгөөг хавсралт №1-ээр баталсугай.

ХОЁР. Төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг эхлүүлж, тухай бүрт нь үр дүнг тооцон ажиллахыг ТУЗ-ийн нийт гишүүдэд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ДӨЛБАДРАХ



БӨӨНИЙ ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 4сарын 5 өдөр

Дугаар №ХЭ2014001

Улаанбаатар хот

2013 оны санхүүгийн тайланг дүгнэх тухай

Бөөний худалдаа ХК-ийн 2014 оны 4 сарын 5-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тооллогын комиссын дүнг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

НЭГ. Компанийн 2013 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлттэй танилцан Интер Аудит ХХК-ийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, өгсөн зөвлөмжийг биелүүлэхийг ТУЗ-ийн нийт гишүүдэд даалгасугай.

ХОЁР. Санхүүгийн тайлан дээр илэрсэн алдаа дутагдлыг арилган ажиллахыг гүйцэтгэх захирал Б.Очбадрахд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ДӨЛБАДРАХ



## ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэн томилох тухай

Бөөний худалдаа ХК-ийн 2014 оны 4 сарын 5-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тооллогын комиссын дүнг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

НЭГ.Хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналыг авсан дараах хүмүүсийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгосныг баталсугай

1. Б.Дөлбадрах
2. Б.Илчбадрах
3. Б.Очбадрах
4. Ж.Бадарч
5. Д.Мөнгөнцэцэг
6. Б.Болд

ХОЁР. Хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналыг авч, хараат бус гишүүний шаардлагыг хангасан дараах хүмүүсийг хараат бус гишүүнээр баталсугай.

1. Ү.Нармандах
2. А.Болоржаргал
3. Б.Батцэцэг

ГУРАВ. ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон нийт хүмүүст баяр хүргэж, Компанийн засаглалын Кодексыг хэрэгжүүлэхийг даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ДӨЛБАДРАХ



БӨӨНИЙ ХУДАЛДАА ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 4сарын 5 өдөр

Дугаар №ХЭ2014005

Улаанбаатар хот

Компанийн хэлбэрийг өөрчлөх төсөл бэлтгэх тухай

Бөөний худалдаа ХК-ийн 2014 оны 4 сарын 5-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тооллогын комиссын дүнг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62.1.4 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

НЭГ. Компанийн хэлбэрийг өөрчлөхөөр ТУЗ-өөс гаргасан саналыг үндэслэлтэй гэж үзэн дэмжсүгэй.


ХОЁР. Компанийн хэлбэрийг өөрчлөх болсонтой холбогдуулан Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай төсөл боловсруулахыг ТУЗ-ийн нийт гишүүдэд даалгасугай.

ГУРАВ. Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай төслийг боловсруулахдаа мэргэжлийн экспертийн баг ажиллуулахыг ТУЗ-д зөвшөөрсүгэй.

ДӨРӨВ. Төслийн судалгааг үндэслэлтэй хийж, дараахи мэдээллүүдийн цогц шинжилгээг гаргасугай.

- Хэлбэрийг өөрчлөх зорилго
- Нөхцөл
- Журам
- Хувьцааг харилцан хөрвүүлэх арга
- Тооцоо
- Өөрчлөлт оруулах хугацаа
- Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах хугацаа

ТАВ. Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай асуудлыг зарчмын хувьд дэмжин, төсөл боловсруулж танилцуулсаны дараа ахин хэлэлцэхээр тогтсугай.

ХУРЛЫН ДАРГА  Б.ДӨЛБАДРАХ

